



Сайн сайхны төлөө!



2021

үйл ажиллагааны тайлан

АГУУЛГА

1 Компанийн танилцуулга

2 Оны онцлог үйл явдал

3 Газар тариалан

4 Гурилын үйлдвэрлэл

5 Санхүүгийн үр дүн

6 Чанар, ХАБЭА, нийгмийн хариуцлага

7 Эрсдлийн удирдлага

8 Хувьцааны арилжаа

Компанийн хураангуй танилцуулга



“Хөвсгөл Алтандуулга” ХК	
Улсын бүртгэлийн дугаар	1710001001
Регистрийн дугаар	2034565
Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.25
Үйл ажиллагааны чиглэл	Үр тариа үйлдвэрлэл
	Гурил үйлдвэрлэл
	Малын тэжээлийн үйлдвэрлэл
	Хүнсний ногоо тариалах
	Гадаад дотоод худалдаа
	Малын аж ахуй
	Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа
Хувь нийлүүлсэн хөрөнгө	157,342 мянган төгрөг
Компанийн хаяг	Хөвсгөл, Тариалан, Мандал
Холбоо барих утас	70386030, 77116031
Хувьцаа эзэмшигчдийн тоо	486 хувьцаа эзэмшигчидтэй (2021.12.27 байдлаар)

2021 оны Онцлох үйл явдал

Газар тариалангийн үйлдвэрлэлийг тусгаарлав

- Хувьцаа эзэмшигчдийн 2021/04/16-ны өдрийн ээлжит хурлаар ГТ-ийн үйлдвэрлэлийг тусгаарлан охин компани байгуулах шийдвэрийг гаргав
- Тусгаарлах замаар өөрчлөн байгуулах журам, тусгаарлах ажлыг зохион байгуулж ажиллах комиссыг ТУЗ-ийн хурлын 2021/3/20-ны өдрийн тогтоолоор батлав
- “Алтан хажир” ХХК 3,2 тэрбум төг-ийн хөрөнгөтэй, 16 ажилтантайгаар байгуулагдав

Мөрөн хотод бөөний борлуулалтыг эхлүүлэв

- Мөрөн хот дахь “Тэсийнх” агуулахын барилгыг засварлан нэрийн дэлгүүр нээж, агуулах бөөний борлуулалтын цэг байгуулав.



Газар тариаланд ашиглагдаагүй талбайг түрээслүүлэх туршилтыг эхлүүлэв

- 697 га талбайг иргэдэд түрээслүүлж, бүтээгдхүүн худалдан авах гэрээг байгуулж санхүүжилтийг аван үйлдвэрлэлийн зардалд ашиглалаа
- Улаанбуудайн үр үржүүлгийн ажлыг үргэлжлүүлэн сунгаж 666 га талбайд үр үржүүлгийн ажил хийгдэв.

Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4-р сарын 16-ны өдөр 87.2 хувийн ирцтэйгээр УБ хотод хуралдаж дараахь асуудлуудыг хэлэлцлээ.

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал
- Хувьцаа эзэмшигчдийн 2021/04/16-ны өдрийн ээлжит хурлаар ГТ-ийн үйлдвэрлэлийг тусгаарлан охин компани байгуулах шийдвэрийг гаргав

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

ТУЗ нь 9 гишүүнтэй, 2021 онд хурал болон эчнээ санал хураалтаар дараахь асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын зардлын төсөв
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай
- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дотоод аудитын тайлан, ТУЗ-ийн дүгнэлт
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах журам, тусгаарлах ажлыг зохион байгуулж ажиллах комиссыг ТУЗ-ийн хурлын 2021/3/20-ны өдрийн тогтоолоор батлав. Комисс орон нутагт тухайн талбарт ирж ажиллав.
- Арилжааны банкнаас зээл авахыг дэмжих
- МХСангийн зээлийн үлдэгдэлийг төлж барагдуулахыг дэмжих

Алтан хажир ХХК-ийн үйл ажиллагаа

2021 оны 4 сарын 16-ны ХЭХ-аар шийдвэр гарч Алтан Хажир ХХК байгуулан газар тариалангийн үйлдвэрлэлийг дагнан гүйцэтгэж байна



Таримлын төрөл	Тариалалт /га/
Улаанбуудай	3706
Арвай	102
Овьёос	56
Вандуй	47
Ногоон тэжээл	110
Нийт	4021

Тариалалт, ургац хураалт

- Тариалалтад өөрийн нөөцөлсөн 400 тн, ХААДС-аас элит 190 тн буудайн үр худалдан авч ашиглав
- Гумат, нийлмэл, азот, азофосын бордоо 120 тн-ыг авч, 100 тн-ыг ашиглав
- Ургамал хамгааллын ажлыг давхардсан тоогоор 7920 га-д хийлээ.

Уринш ба бусад үйл ажиллагаа

- Уриншийг нийт 2384 га талбайд цомхотгосон технологиор хийв
- Хөндийн 1441 га талбайг буюу 19 км хашааг барих ажлыг өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэлээ
- Ургамлын өвчин хортон, хог ургамлын тархалт, түүнтэй тэмцэх чиглэлээр мэргэжилтнүүдтэй зөвлөхийн гэрээг байгуулан ажиллалаа.

Гурилын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа


Компани 2021 онд 30 мян.тн үр тариа өөрийн үтрэмд хүлээн авч нийт давхардсани тоогоор 106 үндсэн болон түр ажилтан, орон нутгийн МСҮТ-ийн оюутан, зэвсэгт хүчний албан хаагчид ажиллан Гурилын үйлдвэрийн түүхий эдийг бэлтгэхээс гадна ойр орчмын сумдын малчидад хивэг, тэжээл нийлүүлэхэд гар бие оролцон ажилласан байна.



- Үтрэмээс үйлдвэрийн цэвэрлэх тасагт 7,258,182 кг улаанбуудай хүлээн авч, цэвэрлэн, 3,5%-ийн хорогдол гаргасан байна.
- Тээрэмдэлтийн бүх системээс дээж авч шинжилгээ хийн, урсгал засвар цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь тогтмол хийж үйлдвэрийг хортон шавьж, мэрэгчээс хамгаалав.
- 2021 онд гурилын үйлдвэрлэлийг тасралтгүй ажиллуулахад түүхий эдээр хангах зорилтыг биелүүлсний зэрэгцээ БНХАУ-д гурил экспортлох аж ахуйн нэгжийн нэг болсон амжилттай ажиллаа.
- 2020 онд захиалсан ариутгалын кабиныг мөн суурилуулан ашиглалтанд оруулав.

Гурилын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

Борлуулалтын харьцуулалт, оноор




- Гурил үйлдвэрлэл 2021 онд нийт 10517 тн буудай тээрэмдэхээс нийт 7258,2 тн буудай тээрэмджээ.
- Бүхэл үрийн гурил Хөвсгөл аймгийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарсан бөгөөд цагт 500кг бүхэл үрийн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай, түүхий эд холигч, шанаган дамжуулагч бүхий 25кг, 5кг-аар савлах тоног төхөөрөмжийг Хятад улсаас суурилуулж угсрав
- Бүтээгдэхүүний үнслэг, хүчиллэг, метал хольц шинжлэх багаж болон үр тарианы шинжилгээний стандартын ширээг авч суурьлуулсан

Санхүүгийн үр дүн

	2020 он мян.төг	2021 он мян.төг
Санхүүгийн орлого	7,140,299.0	10,423,937.5
Үр тариа, тэжээлийн борлуулалт	1,726,278.1	2,955,980.0
Гурил, хивэг борлуулалт	5,414,020.9	6,676,452.6
Нийт санхүүгийн орлого	7,140,299.0	9,632,432.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5,522,708.0	9,173,065.0
Нийт ашиг	1,617,591.0	1,250,872.5
Боловсон хүчний холбогдолтой зардал	309,086.4	384,574.8
Ерөнхий удирдлагын бусад зардал	925,746.2	464,757.8
Үйл ажиллагааны нийт зардал	1,234,832.6	849,332.6
Үйл ажиллагааны цэвэр ашиг	382,758.4	401,539.9
Санхүүгийн зардал	86,346.0	516,333.0
Ердийн бус орлого	772,221.9	260,023.4
Татварын өмнөх орлого	1,068,634.3	145,230.3
Татварын зардал	57,514.7	16,043.6
Тухайн үеийн цэвэр ашиг	1,011,119.6	129,186.7

Нийт 10.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 9.2 тэрбум төгрөгийн өртөг гаргаж, 0.1 тэрбум төг-ийн нийт ашигтай, 0.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.

Борлуулалтын орлого, оноор



Санхүүгийн байдлын тайлан

- Дотоод аудиторын зөвлөмжийн дагуу бараа материалын бүртгэл, дотоод мэдээ, тайлангийн системийг оновчтой болгох ажлыг хэрэгжүүлж байна.
- 2021 онд шинээр Төрийн банкнаас эргэлтийн хөрөнгийн 3,3 тэрбум төг-ийн зээл, хөнгөлттэй эх үүсвэрийн 1,3 тэрбум төг-ийн зээл авлаа.
- Банкнуудаас авсан зээлээс 0.6 тэрбум төгрөг, МХС-аас авсан зээлийн үлдэгдэл 3,1 тэрбум төгрөгийн өрийг төлж дуусгав.
- 2021 онд 10.4 тэрбум төг-ийн борлуулалт хийж, орлогын төлөвлөгөөний биелэлт 88.9%-тай байна.

Балансын зүйл	2020 он мян.төг	2021 он мян.төг
Хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	191,584.6	778,877.5
Худалдааны авлага	1,299,955.0	2,541,403.5
Бараа материал	2,249,063.7	6,202,301.4
Бусад авлага	2,095,224.6	871,046.8
Нийт эргэлтийн хөрөнгө	5,835,827.9	10,393,629.2
Цэвэр үндсэн хөрөнгө	11,034,546.4	10,600,315.0
Нийт хөрөнгө	16,870,374.3	20,993,944.2
Богино хугацаат өглөг	5,158,737.5	7,767,953.5
Урт хугацаат өглөг	773,870.0	2,159,037.2
Нийт өр төлбөр	5,932,607.5	9,926,990.7
Хувь нийлүүлсэн хөрөнгө	157,342.0	157,342.0
Халаасны хувьцаа	- 531,647.9	- 531,647.9
Нэмж төлөгдсөн капитал	3,355,642.7	3,355,642.7
Хөрөнгийн дахин үнэлгээ	4,479,965.4	4,479,965.4
Хуримтлагдсан ашиг	3,476,464.6	3,605,651.3
Нийт цэвэр хөрөнгө	10,937,766.8	11,066,953.5
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	16,870,374.3	20,993,944.2

Чанар, ХАБЭА

- Эрдэс бордоо импортлох, хэрэглэх, түр хадгалах, борлуулах төсөл боловсруулах үйл ажиллагааг эхлүүлэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 ОУ-н стандартын магадлах аудитын хүрээнд өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхээр нэгжийн удирдлагуудтай хамтран ажиллалаа
- Бүтээгдэхүүний чанарт нөлөөлж болох бүхий л үзүүлэлтээр гадаад хяналтын шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораториудад дээж илгээж баталгаажуулж дүгнэлтийг тогтмол хийлгэж байна.
- Компанийн өдөр тутмын үйл ажиллагаа болон нэгжүүдийн үйл ажиллагаанд эрүүл ахуй, чанарын хяналтыг тогтмол хийж хэвшүүллээ
- Нийт 2800 мкв талбайд халдваргүйжүүлэлтийг 0.03% жавилионаар шүрших аргаар хийв.
- ГТ-ийн үйлдвэрлэлээс гарч буй хортой хог хаягдал буюу хор бордооны савыг мэргэжлийн байгууллагыг байлцуулан заасан цэгт шатаах аргаар устгалд оруулж бүртгэлжүүлэн ажиллалаа
- Үтрэмийн талбайн агаарын нисэлтийн утасыг транспорматороос авто өргөгч хүртэлх хэсгийг газар доогуурх шугамаар шийдэв.



Нийгмийн хариуцлага

- Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг Аймгийн нэгдсэн эмнэлэг, СЭМ төвтэй хамтран зохион байгууллаа
- Ажилтнуудыг дархлаажуулах зорилгоор 3–4 удаагийн шат дараалсан витаминжуулалтанд хамруулан дэмжин ажилласан.
- Цар тахлын хөл хрионы үеэр галын цэгт ажилласан орон нутгийн эмнэлгийн бүх ажилтнууд, онцгой байдлын албаны нийт ажилтан албан хаагч болон сумын эмнэлгийн ковидоор эмчлүүлэгсдийн хэсэгт өөрийн бүтээгдэхүүний хандив тусламжийг хүргүүлсэн.
- Мөн орон нутгийн хүүхэд багачуудад жил бүр уламжлал болгон хүргэдэг хандив тусламж, бэлэгийг хүргүүлсэн байна.
- Малчид болон бүтээгдэхүүн хэрэглэгчидэд хүргэх бүтээгдэхүүний үнийн хамгийн доод, тогтвортой байх бодлого барьж ажилласан.
- Улирлын чанартай ажилд орон нутгийн иргэдийг илүүтэйгүүр хамруулж, цагийн ажлын байрыг туршин ажиллаж үзэв.

- *Эрсдлийн удирдлага*

- Зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлээ тогтвортой явуулж, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд тогтмол нийлүүлж, бүтээгдэхүүний чанарт анхаарч байна. Мөн бүтээгдэхүүний үнийг харьцангуй тогтвортой байлгах бодлогыг баримталж байна.
- Компани 2021 оны ургац хүртэл үйлдвэрлэлээ тогтвортой явуулах түүхий эдийн нөөцийг бүрдүүлж чадсан боловч түүхий эдийн чанараас хамаарч гурилын үйлдвэрлэл төлөвлөсөн хэмжээнд хүрсэнгүй.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, чанарын хяналтыг сайжруулах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. Энэ ажлын хүрээнд үтрэмийн ажиллагсдын амрах байрыг сайжруулж, үтрэмийн лаборатори, үр тариа жинлэн хүлээж авах пүүний хэсгийг нэг цэгт төвлөрүүлэн өргөтгөлөө.



Хувьцааны арилжаа

- ADU хувьцаа нь 2019 оны ТОП-20 индексийн багцыг бүрдүүлэх үнэт цаасаар шалгарч, сагсыг бүрдүүлэгч болсон ба хувьцааны ханш 2021 онд 638-551 төгрөгийн хооронд арилжаалагдсан байна.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцааны арилжаа явагдсан өдрийн тоо 50 хувиар нэмэгдэж, хувьцаа эзэмшигчдийн тоо 14 хувь өссөн, нийт арилжааны үнийн дүн 5 дахин буурсан үзүүлэлттэй байна.
- 2021 оны эцэст хувьцаа эзэмшигчдийн тоо 486 болсон байна.